

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/17

Арвайхээр


Дадлага сургуулилтын бэлэн байдлыг хангах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, "Гамшгаас хамгаалах тухай" хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааны 24 дүгээр тэмдэглэл, Шадар сайдын 2020 оны оны "Ковид-19 халдварт цартахалтай тэмцэх бэлэн байдлын дадлага сургуулилт зохион байгуулах тухай" 33 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2020 оны "Дадлага сургуулилт зохион байгуулах тухай" А/266 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. КОВИД-19 халдварт цартахалтай тэмцэх дадлага сургуулилтийн бэлэн байдлыг хангахад Эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, эмнэлгийн тусламжийн бэлэн байдлыг хангах төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дадлага, сургуулилтын бэлтгэлийг хангаж, шаардлагатай санхүүжилтийн тооцоог хийж, байгууллагын батлагдсан төсвийн хүрээнд шийдвэрлэх, зайлшгүй шаардлагатай нэмэлт санхүүжилтийг аймгийн онцгой комисс болон сумын онцгой комисстой хамтран шийдвэрлүүлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ үзүүлэх чадавхийг сайжруулж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.


3. Дадлага сургуулилтанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (М.Золзаяа)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хяналт-шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга (Я.Жаргал)-д тус тус даалгасугай.

ДАРГА  Д.ШИВААННҮРДЭВ



103000044

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны
05.р сарын 05-ны өдрийн А/17 тушаалын
нэгдүгээр хавсралт



**МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫН
ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн
ахлагч:

М.Золзаяа, Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга

Штабын чиглүүлэгч:

Ю.Ичинноров, Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга

С.Дуламсүрэн, Нөхөн үржихүй, өсвөрийн эрүүл мэнд,
хариуцсан ахлах мэргэжилтэн

Мэргэжил арга зүйн
дэмжлэг үзүүлэх

Б.Валя, Захиргаа санхүү нийтлэг үйлчилгээний албаны
дарга

Багийн гишүүд

Н.Оюунтуяа, Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга,
Н.Төгс-Очир, Хүний нөөцийн хангалт, сургалт
сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

Ж.Болзол, Хууль эрх зүй хариуцсан ахлах мэргэжилтэн

Н.Дэжидням, Эмийн чанар аюулгүй байдал хариуцсан
мэргэжилтэн

П.Цэнгэлбаяр, Олон нийттэй харилцах ажилтан


Б.Оюунчимэг, Эрүүл мэндийн боловсрол, мэдээлэл
сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

Ажлын хэсгийн
нарийн бичиг

М.Ганцэцэг, Яаралтай, Гамшигийн үеийн тусламж
хариуцсан мэргэжилтэн

Ц.Энхтайван, Архив бичиг хэргийн ажилтан

Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 15 сарын 15-ны өдрийн тушаалын хоёрдугаар хавсралт



“КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАРТАХЛЫН ДАДЛАГА СУРГУУЛИЛТИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙН
БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

2020.05.04

Арвайхээр

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
1	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн халдварт сүрьеэгийн тасгийн тусгаарлах эмнэлгийн бэлэн байдлыг хангах	05-р сарын 04	БОЭТ	ЭМГ
2	Политехник коллежийн 200 ортой 1-р дотуур байрыг тусгаарлан ажиглах байраар бэлтгэж шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл тоног төхөөрөмжөөр хангах	05-р сарын 04-06	Политехник коллеж, ӨЭМТ	ЭМГ
3	Олимп амралтын хотхонд 50 ортой хээрийн эмнэлэг дэлгэх бэлтгэл ажлыг хангаж, эмнэлэгт ажиллах хүний нөөцийг томилон сургаж чадавхижуулсан байх	05-р сарын 02-оос 05-р сарын 04 хүртэл	ЭМГ, ӨЭМТ	ОБГ, ЦГ, ЗХ-256-р анги, МХГ
4	Дэлгэсэн эмнэлэгт ариутгал халдваргүйжүүлэлт хийх, халдваргүйтгэлийн бодисын нөөцийг бүрдүүлэх	05-р сарын 06-08	ЗӨСТ	ЭМГ
5	Халдварын хяналт сэргийлэлтийн зөвлөгөө өгч ажиллах /өрөөний урсгал, хамгаалах хэрэгслийг ашиглах г.м/	05 сарын 06-аас 05-р сарын 08	ЭМГ, БОЭТ, ЗӨСТ	МХГ
6	Дадлага, сургуулилын бэлэн, байдлыг хангахад шаардагдах санхүүжилтын тооцоог хийж, байгууллагын төсвөөр шийдвэрлэх, нэмэлт шаардлагатай санхүүжилтийг Аймаг, сумын онцгой комиссоор шийдвэрлүүлэх	05-р сарын 04	БОЭТ, Сум, өрхийн ЭМТ, Хувийн хэвшлийн эмнэлгүүд	ЭМГ-ЗСНУА
7	Нийтийг хамарсан гамшиг, аюулт үзэгдлийн	05-р сарын 06-08	ЭМГ, ОБГ, ЦГ, МХГ	БОЭТ, Хувийн хэвшлийн

	улмаас эмнэлгийн байрыг ашиглах боломжгүй болсон тохиолдолд эмнэлгийг Ачтан-Ирээдүй, Ариунсанаа хувийн хэвшлийн эмнэлэг рүү түр шилжүүлэх төлөвлөлт, хийж бэлэн байдлыг хангах			эмнэлгүүд
8	Эрүүл мэндийн байгууллагуудын цогцос хадгалах байрыг бэлтгэх, хэрхэн чандарлах талаар төлөвлөлт хийж, бэлтгэл ажлыг хангах	05-р сарын 01-ээс 05-р сарын 31 хүртэл	ОБГ,ЭМГ, МХГ,ЦГ,ТГ	БОЭТ, Сум, өрхийн ЭМТ, Хувийн хэвшлийн эмнэлгүүд
9	ЭМБ-уудын аюултай хог хаягдал зөөвөрлөх, хадгалах, тусгаарлах, устгах маршрут гаргах	05-р сарын 01-ээс 05-р сарын 31 хүртэл	БОЭТ, Сум, өрхийн ЭМТ, Хувийн хэвшлийн эмнэлгүүд	ЭМГ
10	Эмч, эмнэлгийн ажилтны сэтгэцийн болон сэтгэл зүйн өөрчлөлтийн үед зөвлөгөө, засал хийх эмч мэргэжилтийг бэлтгэх, сургах	05-р сарын 01-ээс 05-р сарын 31 хүртэл	БОЭТ, ЭМГ	Сум, өрхийн ЭМТ, Хувийн хэвшлийн эмнэлгүүд
11	Цаг үеийн байдалтай холбоотой мэдээ мэдээллээр хангах	05-р сарын 01-ээс 05-р сарын 08	Эрсдлийн мэдээлэл харилцааны баг	БОЭТ, Сум, өрхийн ЭМТ, Хувийн хэвшлийн эмнэлгүүд
12	Дадлага сургуулийн бэлэн байдлыг хангасан талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг хүргүүлэх	05-р сарын 09-өөс 05-р сарын 10	БОЭТ, Сум, өрхийн ЭМТ, Хувийн хэвшлийн эмнэлгүүд	ЭМГ

Хүрэх үр дүн:

1. Эрүүл мэндийн байгууллагуудын Ковид-19 халдварт цартахалтай тэмцэх эмнэлгийн тусламжийн бэлэн байдлыг хангуулж, хариу арга хэмжээний байдалд үнэлгээ өгсөн байна.
2. Сургамжид үндэслэн цаашдын бэлэн байдлыг хангах төлөвлөгөөнд тодотгол хийнэ.

-----oO-----